

ТАНИЛЦУУЛГА

Галт зэвсгийн тухай хуулийн
шинэчилсэн найруулгын
төслийн талаар

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т “Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн.” гэж заасан.

Монгол Улсын хэмжээнд иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд 50472 гаруй галт зэвсэг бүртгэлтэй байгаагаас 95.4 хувь нь ан агнуурын зориулалтаар, үлдэх хэсэг нь харуул хамгаалалт, спорт сургалт, үзмэр урлагийн болон цуглуулгын зориулалтаар хэрэглэгддэг байна. Улсын хэмжээнд жилд дунджаар 1418 орчим галт зэвсгийг иргэн, хуулийн этгээд шинээр худалдан авч өмчилж, эзэмшиж байна.

Галт зэвсгээр үйлдэгдсэн хэргийн талаарх тоон мэдээллээр 2020-2025 оноор авч үзвэл,

Гэмт хэрэг, зөрчлийн төрөл	Үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоо					
	2020	2021	2022	2023	2024	2025
Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг						
20.4 дүгээр зүйл. Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших						
1.Байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар олж авсан, шилжүүлсэн, борлуулсан, тээвэрлэсэн, хадгалсан	2	1	1	3	2	3
2.Галт зэвсэг, галт хэрэглэл сум ашиглаж үйлдсэн Эрүүгийн хуульд бусад гэмт хэрэг	38	33	42	35	19	23
Зөрчлийн хэрэг						
1.Хууль бусаар тусгай хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, агсамжийг биедээ авч явсан, хадгалсан	1	-	4	2	-	-
2.Иргэний, эсхүл харуул хамгаалалтын зориулалттайгаас өөр төрлийн галт зэвсэг өмчилсөн, эсхүл эзэмшсэн	1	-	-	-	-	-

3.Хуульд зааснаас өөр зориулалтаар галт зэвсэг өмчилсөн	-	1	-	1	-	1
4.Хуульд заасны дагуу сургалтад сууж гэрчилгээ аваагүй, хуульд заасан өмчлөх эрхгүй этгээд галт зэвсэг олж авсан, эзэмшсэн, ашигласан	9	10	4	10	9	9
5.Галт зэвсэг бүртгүүлэх, хадгалах, ашиглах, эзэмших, худалдан авах журам зөрчсөн	6	7	3	11	6	4
6.Галт зэвсэг эзэмшүүлэх гэрээг хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй	1	1	-	-	-	-
7.Галт зэвсэг авч явах, эсхүл тээвэрлэх журам зөрчсөн, эсхүл хуульд заасан хугацаанд галт зэвсгийн тооллогод хамрагдаагүй	3	2	1	2	3	1
Бусад	8	8	5	5	4	8

Гэмт хэрэг, зөрчлийн улсаас 2020 онд 3 хүн гэмтэж, 4 хүний амь нас хохирсон, 2021 онд 8 хүн гэмтэж, 4 хүний амь нас хохирсон, 2022 онд 5 хүн гэмтэж, 5 хүний амь нас хохирсон, 2023 онд 6 хүн гэмтэж, 3 хүний амь нас хохирсон, 2024 онд 4 хүн гэмтэж, 3 хүний амь нас хохирсон, 2025 онд 2 хүн гэмтэж, 5 хүний амь нас хохирсон тохиолдол бүртгэгдсэн ба жилд дунджаар 5 хүн гэмтэж, 4 хүн нас барж байна.

Үүний шалтгаан нөхцөл нь галт зэвсгийн хадгалалт, хамгаалалт, галт зэвсэгтэй харьцах асуудалтай холбоотой юм.

Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын 2025 онд хийсэн галт зэвсгийн тооллогоор 1816 галт зэвсгийг шинээр гэрчилгээжүүлж, 8,716,800 мянган төгрөгийн хураамж төлүүлсэн, улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа ... галт зэвсгээс 6 галт зэвсгийг илрүүлж, зөрчлийн улмаас 21, гэмт хэргийн улмаас 43, бусад үндэслэлээр 43 галт зэвсгийг хурааж, нуугдмал 46 галт зэвсгийг илрүүлэн, галт зэвсэг, сум хууль бусаар худалдаалж болзошгүй 5 хувь хүнийг бүртгэл хяналтанд авч, галт зэвсэгтэй холбоотой нийт 21 зөрчлийг илрүүлэн 840,000 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

Хуулийн төсөл нь Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомж, тус хуульд хэрэглэгдэх нэр томъёоны тодорхойлолтыг тусгаж өгсөн болно. Нэр томъёоны хэсэгт Эрүүгийн хуультай нийцүүлэн “галт хэрэгсэл” гэх ойлголтыг шинээр, галт зэвсгийн зориулалтаар нь ангилсан төрөл тус бүрийн тодорхойлолтыг тусгайлан зааж, галт хэрэгсэлд хамаарах зүйлсийг цаг үеийн шаардлагад нийцүүлэн дэлгэрүүлэн тусгав.

Хоёрдугаар бүлэгт галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумны зориулалтын талаар тусгасан бөгөөд галт зэвсгийг зориулалтаас нь хамааруулж ан агнуурын, спорт-сургалтын, харуул хамгаалалтын, үзмэр, цуглуулгын, хууль сахиулах албаны, байдааны болон цэргийн гэсэн үндсэн 6 зориулалт болгон

ангилж, ангилал тус бүрийн онцлог, техникийн үзүүлэлтийг тусгасан болно. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуульд эзэмшиж байгаа этгээдээр дамжуулан ангилсан байгааг өөрчилж, галт зэвсгийг ашиглах зориулалтаар нь ангилав.

Гуравдугаар бүлэгт галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглах, бүртгүүлэх, хадгалах, хязгаарлахтай холбоотой харилцааг зохицуулахдаа иргэн ан агнуурын, спорт-сургалтын болон үзмэр цуглуулгын зориулалтаар галт зэвсгийг өмчлөх эрхтэй байхаар тусгав. Хууль сахиулах албаны болон байлдааны зориулалттай галт зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулахаар заалаа. Мөн галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг ашиглах, эзэмших талаарх ойлголт, зориулалтыг тогтоов. Байгаль хамгаалагч нь 4,5 мм-ээс дээш 12,7 мм хүртэлх калибрийн бянттай болон гөлгөр гол төмөртэй, ажиллагааны хувьд гараар цэнэглэгддэг, автоматаар эсхүл өөрөө цэнэглэгдэх боломжгүй, хүхээгт нь арав, түүнээс цөөн сум орох багтаамжтай, үйлдвэрийн үндсэн хийцийг өөрчлөөгүй галт зэвсгийг эзэмших, ашиглах эрхтэй байхаар зохицуулж, байгаль хамгаалагч галт зэвсэг ашиглах үндэслэлийг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлтээр тусгах төсөл боловсруулсан болно. Иргэн нь ан агнах, спорт-сургалт, үзмэр цуглуулгын галт зэвсэг, гол төмөр худалдаж авсан, улсын хилээр оруулсан бол нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад бүртгүүлэх хүсэлт илгээх, шүүх шинжилгээний байгууллага дээрх галт зэвсгээр буудсан сумны хонгио, хошуу тус бүрээс дээж болгон авч, тухайн галт зэвсэг болон түүнийг эзэмшигчийн талаарх мэдээллийг нэгдсэн санд бүртгэн оруулсны дараа цагдаагийн байгууллага галт зэвсгийг бүртгэх, галт зэвсгийн гэрчилгээ олгох эсэх асуудлаар шийдвэрлэдэг байхаар зохицуулав.

Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэгт галт зэвсэг, сумыг худалдах, худалдаж авах, өвлөх, бэлэглэхтэй холбоотой харилцааг зохицуулахдаа галт зэвсэг, сум, тэдгээрийн дагалдах хэрэгсэл, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, үйлдвэрлэх, нийтэд худалдах, галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх тусгай зөвшөөрөл олгоход хууль зүйн, спорт, байгаль орчин, гадаад худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тагнуул, цагдаа, гаалийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн, тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулах, тусгай зөвшөөрөл олгох, сунгах, галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумыг хилээр оруулах зөвшөөрөл олгох эсэх талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий комисс ажиллахаар тусгаж, комиссын бүрэн эрх, үйл ажиллагаагаа явуулах хэлбэрийн талаар тодорхой зохицуулан, иргэн, хуулийн этгээд галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, галт зэвсгийн гол төмөр, их бие, замаг, цохигч төмрийг борлуулагчаас худалдаж авах болон иргэд хоорондоо галт зэвсэг худалдах, өвлөх, бэлэглэх талаарх эрх зүйн үндсийг тодорхойлов.

Тавдугаар бүлэгт одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуульд журмаар зохицуулахаар заасан галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг импортлох, нийтэд худалдах болон сум дахин цэнэглэх, үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын асуудал, тусгай зөвшөөрөл хүсэгч болон зориулалтын байгууламжид тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт явуулах журам, тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөлтэй этгээд салбар нээх талаарх зохицуулалтыг тусгалаа.

Зургаадугаар бүлэгт галт зэвсэг, адилтгах хэрэгсэл, сум зэргийг худалдаалах тусгай зөвшөөрөл бүхий төвийн үйл ажиллагааны зохион байгуулалт, аюулгүй байдлыг хангах, тухайн төвд үйл ажиллагаа явуулах борлуулагчид тавигдах шаардлага, барилга байгууламжийн стандартыг тогтоож өгөв.

Долоодугаар бүлгээр галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл улсын хилээр нэвтрүүлэх журам, иргэн хуулиар хориглоогүй нэг галт зэвсгийг жилд нэг удаа улсын хилээр оруулах эрхтэй бөгөөд галт зэвсгийн хууль бус эргэлтээс сэргийлэх зорилгоор иргэн өөрөө өмчлөх зорилгоор оруулж ирсэн галт зэвсгийг оруулж ирснээс хойш гурван жилийн дотор бусдад худалдах, бэлэглэхийг хориглох байдлаар тусгав. Түүнчэн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэхтэй холбоотой эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, мэдээлэл солилцох, хяналт хэрэгжүүлэхтэй асуудлыг зохицуулав.

Галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл хүсэлт гаргах, түүнийг шийдвэрлэх журам, холбогдох эрх бүхий байгууллагуудын чиг үүрэг, хилээр нэвтрүүлэхийг хүссэн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэлд гаалийн шалгалт хийх талаар өмнө нь захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байсан харилцааг тусгав.

Наймдугаар бүлэгт галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сум үйлдвэрлэх, сум дахин цэнэглэхтэй холбоотой шинэ зохицуулалт тусгалаа. Үйлдвэрлэгч нь цагдаагийн төв байгууллагад үйлдвэрлэсэн, экспортолсон, худалдсан, устгасан галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сумны нэр төрөл, сери /цуврал/ дугаар, тоо ширхэг, байршлыг нарийвчлан тусгасан мэдээллийг хүргүүлж байх, галт зэвсэг, галт зэвсэгтэй адилтгах хэрэгсэл, сум үйлдвэрлэх, сум дахин цэнэглэх үйлдвэрийн болон хадгалах байр, агуулах нь аюулгүйн бүсийн стандарт, сум үйлдвэрлэх, дахин цэнэглэхэд тавигдах шаардлага, уг үйл ажиллагаанд хориглох зүйлийг тодорхойлов.

Есдүгээр бүлэгт Спорт-сургалтын зориулалтаар галт зэвсэг ашиглах болон нийтэд худалдаалах төв нь буудлага үйлдэх байгууламж /тир/-тэй байх бөгөөд, түүний төрлийг битүү, хагас битүү, задгай байхаар зааж, төрөл тус бүрт тавигдах шаардлагыг тогтоолоо.

Аравдугаар бүлэгт эрх бүхий албан тушаалтан иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг хураах үндэслэл, хураагдсан галт зэвсгийг холбогдох байгууллага хүлээж авах, хадгалах журмыг тусгаж, галт зэвсгийг хураасантай холбоотой гаргах шийдвэрийн төрөл, галт зэвсгийг устгах, өмчлөгчид буцаан олгох, шилжүүлэх зэрэг одоо захиргааны хэм хэмжээний актаар зохицуулагдаж байгаа харилцааг хуулийн төсөлд тусгалаа.

Арваннэгдүгээр бүлэг буюу бусад хэсэгт галт зэвсэг, сум, галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг тээвэрлэх журам, нэгдсэн тооллого хийх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, галт зэвсгийн зориулалт өөрчлөгдөж байгаатай холбоотой шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгаж хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг дагалдуулан байгаль хамгаалагчийн хэрэглэх галт зэвсгийг тодорхойлж өгсөнтэй холбоотойгоор байгаль хамгаалагчийн галт зэвсэг хэрэглэх журмын зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд тусгахаар холбогдох хуулийн төслүүдийг боловсруулсан болно. Мөн Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлд “ангийн буу” гэж нэр томьёоны тодорхойлолт байгааг Галт зэвсгийн тухай хуулийн төсөлд нийцүүлэн эшлэн хэрэглэхээр өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулав.

Эрүүгийн хуулийн 18.5 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт “сум” гэдгийг тусгаагүйгээс гэмт хэрэгт зүйлчлэл хийхэд хүндрэлтэй байдал үүсч гэмт хэргээс ял завших боломжтэй зохицуулалт байгааг засах зорилгоор мөн зүйлд “сум” гэснийг нэмэх болон галт зэвсэг, сум үйлдвэрлэх, сум дахин цэнэглэх үйл ажиллагааны зохицуулалт ору ирж байгаатай холбоотойгоор Эрүүгийн хуулийн 20.5 заасан гэмт

хэргийн объектив талд “сум хууль бусаар үйлдвэрлэсэн, дахин цэнэглэсэн” үйлдлийг нэмж тусгахаар хуулийн төсөл боловсруулав.

Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд Хууль бусаар зэвсэг эзэмших талаарх зөрчилд оногдуулах хариуцлагыг тогтоож өгсөн байгаад Галт зэвсгийн тухай хуульд шинээр орж ирж байгаа зохицуулалттай уялдуулан хуулийн этгээдэд хамаарах зарим төрлийн зөрчил нэмэх талаар тусгасан хуулийн төсөл боловсрууллаа.

Галт зэвсгийн тухай хуулийн төсөлд галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг бүртгэлжүүлэх, гэрчилгээтэй байх талаар зохицуулалт туссантай холбогдуулан Галт зэвсгийн албан татварын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулиудад галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг өмчлөх, бүртгүүлэхтэй холбоотой татвар, тэмдэгтийн хураамжийн зохицуулалтыг тусгахаар нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг, Галт зэвсгийн тухай хуульд галт зэвсэг, сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгохоор заасантай нийцүүлэн Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлд заасан сонгол шалгаруулалтын журмаар олгох тусгах зөвшөөрлийн жагсаалтад Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг буюу “галт зэвсэг, сум үйлдвэрлэх, дахин цэнэглэх тусгай зөвшөөрөл”-ийг нэмж тусгахаар хуулийн төслийг дагалдуулан боловсруулав.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ